ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ
16101, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо,
Дунд гол, Утас/Факс: (976) 70172177
И-мэйл: tpp2@tpp2.energy.mn,
Вэбсайт: www.tpp2.mn

2020. 12. 22 № 01/516
танай ______-ны №______-т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД

Тус компанийн Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 13 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.МИНЖИНХҮҮ

3600 1829

Alban bichig A52020

“ДУЛААНЫ ХОЁРДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2020.12.22 Улаанбаатар хот.

| Д/д | Үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндэслэл | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Нэг. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр: | | | | | |
| 1 | Шинээр боловсруулж байгаа болон нэмэлт өөрчлөлт оруулж байгаа журам, дүрмийн төсөлд ажилтнуудын болон сонирхогч бүлгийн саналыг тусгах арга хэмжээ авах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.* | -Төсөлд ажилтнууд болон сонирхогч бүлгээс санал өгөх боломжийг бүрдүүлэх<br>-Төслийн талаар ажилтнуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах,<br>-Эрх бүхий этгээдээр батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах | Тухай бүр | Хуулийн мэргэжилтэн, холбогдох нэгжийн ажилтан | 2020 онд:<br>1. Компанийн ажилтнуудад орон сууц, хашаа байшин худалдан авах, нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулсан<br>2. Хийн баллон ашиглах журам шинээр боловсруулсан<br>3. Химийн бодис хадгалах, тээвэрлэх ашиглах журам шинээр боловсруулсан<br>4. Спорт цогцолборын ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулсан<br>5. Компанийн ажилтны эзгүй байгаа хугацаанд ажил албан тушаалыг хавсран болон түр орон гүйцэтгэх журамд нэмэлт өөрчлөлт<br>6.Ажилтны ёс зүйн дүрэмд шинэчлэн найруулга хийсэн.<br>Төслийг тухай бүр холбогдох ажилтнууд болон нэгжүүдэд хүргүүлж санал авч ажиллав. Ирүүлсэн саналыг дүрэм, журамд тусган, Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан мөрдүүлж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 2 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;*<br>• *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9.* | -Хуулийн холбогдох заалтыг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн байх,<br>-Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх,<br>-Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл ил тод болсон байх.<br>-Шилэн дансны мэдээллийн ил тод байдалд хяналт тавьж ажилласан байх | Тухай бүр | ЭБАТ, ХАА-ны ахлах мэргэжилтэн, СБХ-ийн ахлах нягтлан бодогч, Дотоод аудитор, ЗУХ-ийн ахлах мэргэжилтэн | “Шилэн дансны тухай” хуулийн хүрээнд Худалдан авах ажиллагааны мэдээллийг цахимд системд байршуулсан байдалд хяналт хийхэд: 4,7 дугаар саруудад мэдээлэл хоцруулсан мэргэжилтнүүдэд анхааруулж, 8-р сарын цалингийн үр дүнг хасч арга хэмжээ авсан. Дахин алдаа дутагдал гараагүй.<br>Концессын мэдээлэл, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд батлан даалт гаргах мэдээ оны эхнээс байхгүй.<br>“Санхүүгийн бусад гэрээ, төсөв, өмч хөрөнгө зарцуулах өр авлага, үүсгэсэн шийдвэр”-ийг тухай бүр оруулах мэдээлэлд 2020.12.22-ны байдлаар 131 тушаал, 24 гэрээ, Сангийн яамны хаалтын гэрээ 10-ыг тус тус байршуулсан байна. |
| 3 | Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, ажилтнуудад мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажиллах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.* | -Дотоод сүлжээг боловсронгуй болгох, хяналт удирдлагын Able программыг судлах, нэвтрүүлэх,<br>-Дотоод сүлжээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт ажилтны хэрэгцээт мэдээллийг шуурхай байршуулан мэдээлж байх,<br>-Дотоод сүлжээний системийг байнга ашиглаж хэвших | Тухай бүр | КМС-ийн инженер, ЗУХ-ийн ажилтнууд | Хяналт удирдлагын Able программыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлж холбогдох мэргэжилтнүүдэд сургалт хийгдэж эхэлсэн боловч санхүүгийн байдлаас шалтгаалж 2021 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан.<br>Дотоод сүлжээний хэвийн ажиллагааг байнга шалган ажиллаж байна.<br>Able программ бүрэн нэвтэрсний дараа дотоод сүлжээний системийг байнга ашиглаж хэвшинэ. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 4 | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.* | -Компанийн цахим хуудас хэвийн ажиллагаатай байх,<br>-Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх,<br>-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байх,<br>-Мэдээлэл нээлттэй, үр ашигтай, хүртээмжтэй байх,<br>-Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааг тогтмол мэдээлэх | Тухай бүр | КМС-ийн инженер, ЗУХ-ийн ажилтнууд | Байгууллагын цахим хуудсанд батлагдсан хуваарийн дагуу хариуцсан ажилтнууд тогтмол баяжуулалт хийж, холбогдох ажилтнаас ирүүлсэн цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. |
| 5 | Авлигын эсрэг үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.* | -Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулсан байх,<br>-Хэрэгжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулсан байх,<br>-Шалгуур үзүүлэлтийг хангаж, үнэлгээнд хамрагдах,<br>-Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байх | Тухай бүр | ЭБАТ, Холбогдох ажилтан | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас болон самбараар танилцуулсан, холбогдох ажилтнуудад тухайлан танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллав.<br>Төлөвлөгөөний биелэлтийг эхний 9 сарын байдлаар, мөн 12 сарын 22-ны байдлаар тус тус гаргаж ЭХЯ-нд хүргүүлсэн. |
| 6 | Эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн, АТГ-т хүргүүлж хянуулж хариуг авах ажлыг зохион байгуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Нийтийн албанд нийтийн болон* | -Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч, бүртгэх,<br>-АТГ-т хүргүүлэн хянуулах,<br>-АТГ-аас ирүүлсэн ХАСУМ хянасан тухай албан бичгийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах | Тухай бүр | Нэр дэвшигч, ЭБАТ | 2020 онд СБХ, ЗУХ-н дарга, Хангамж үйлчилгээ хариуцсан Дэд захирлын албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ыг хүлээн авч АТГ-д хүргүүлэн хянуулж, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох шийдвэрийг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.* | -АТГ-ын дүгнэлтийг үндэслэн томилох шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах | Тухай бүр | Хүний нөөцийн мэргэжилтэн | гаргуулсан. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчид нэр дэвшигч Б.Мягмаржавын ХАСУМ-ыг хянасан АТГ-ийн дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн 2020.08.28-ны өдрийн 15 дугаар тогтоолоор томилсон. |
| 7 | Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсоноос хойш болон томилогдсоноос хойш 30 хоногт (2019*, 2019+) багтаан ХАСХОМ-ийг мэдүүлэх ажлыг зохион байгуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3;*<br>• *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.* | -Шинээр томилогдсон болон хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон мэдүүлэг гаргагчид ХАСХОМ-ээ хугацаанд нь гаргаж мэдүүлсэн байх,<br>-Цахим системд баталгаажуулсан байх | Тухай бүр | Албан тушаалтан, ЭБАТ | Шинээр томилогдсон 3 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлж, цахим системд баталгаажуулсан. |
| 8 | Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг холбогдох албан тушаалтнаас гаргуулан авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн систем, шилэн дансны цахим системд бүртгэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8,6.* | -Мэдэгдлийг холбогдох ажилтнаас тухай бүр гаргуулан авах,<br>-Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем, шилэн дансны цахим системд мэдэгдлийн мэдээллийг бүртгэн оруулсан байх,<br>-Мэдээллийн санг үүсгэн хяналт тавьж ажиллах | Тухай бүр | ЭБАТ, ХАА-ны мэргэжилт-нүүд | 2020 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах 48 тендерийн үнэлгээний хороонд ажилласан 25 гишүүнээр давхардсан тоогоор 254 ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг гаргуулан авч АТГ-ын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсанд мэдээлж ажилласан. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 9 | Мэдүүлэг бүрдүүлэлтийн систем дэх “ЭБАТ” цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөн мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч, албан тушаалтанд холбогдох зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5;*<br>• *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5.* | -Хуульд заасан хугацаанд бүртгэл, бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байх,<br>-Мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад заавар, зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх | Тухай бүр | ЭБАТ | Тус компанийн Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий 16 албан тушаалтнаар хөрөнгө орлогын болон хувийн ашиг сонирхлын 2019 оны мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан ажилласан.<br>Мэдүүлэг бүрдүүлэлтийн систем дэх “ЭБАТ” цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөж, 2020 онд шинээр томилогдсон 2 хэлтсийн дарга, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон 1 албан тушаалтны, Хангамж үйлчилгээ хариуцсан дэд захирлын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргах зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлж, ХАСХОМ-ыг баталгаажуулж ажиллалаа. |
| 10 | Давхар ажил эрхлэлтэд тавих хяналтыг сайжруулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл.* | -Хуулийн холбогдох заалтыг ажилтнуудад таниулах,<br>-Сургалт зохион байгуулах,<br>-Хяналт тавих | Тухай бүр | ЭБАТ, Хуулийн мэргэжилтэн | Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг зөрчсөн үйлдэл гараагүй.<br>Шинээр томилогдсон албан тушаалтанд Холбогдох хуулийн заалтыг танилцуулан ажиллаж байна. |
| 11 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн хэрэгжилтийг хангаж зохион байгуулалтын арга хэмжээ авах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн* | -Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах,<br>-Холбогдох дээд байгууллага, олон нийтэд танилцуулах | Тухай бүр | ЭБАТ, Холбогдох ажилтнууд | 1. АТГ-аас 2020.01.10-ны 01/371 дүгээр албан тоотоор ЭХ-ний сайдад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг 2020.01.29-ний өдөр 01/82 дугаар албан тоотоор ЭХЯ-нд хүргүүлсэн байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;*<br>• *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.* | | | | 2. АТГ-ын 2020.01.24-ний 01/1003 дугаар албан тоотоор ЭХ-ний сайдад хүргүүлсэн зөвлөмжийг Худалдан авах ажиллагааны хэсэг болон холбогдох албан тушаалтанд танилцуулж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.<br>3. АТГ-ын 2020.02.21-ний өдрийн 05/2237 дугаар албан тоотын дагуу холбогдох хуулийн хүрээнд 2020 онд 20 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч бүртгэсэн.<br>4. АТГ-ын 2020.04.10-ны өдрийн 01/4291 дүгээр албан тоотоор ЭХ-ны сайдад хүргүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн ажиллаж байна.<br>5. АТГ-ын 2020.04.23-ны өдрийн 05/5036 дугаар албан тоотын дагуу албан тушаалтнуудын ХАСХОМ, баталгааны маягт, тайлан мэдээний баримтуудыг байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад тусгуулан батлуулж, 70 жил хадгалахаар байгууллагын архивт шилжүүлэн, нууцлалыг ханган ажиллаж байна.<br>6.АТГ-ын 2020.12.04-ний 05/13472 дугаар албан тоотын дагуу зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 12 | Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл, тендерийн үр дүнг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д бүрэн оруулах, байгууллагын цахим хуудсанд тодорхой байршуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1;*<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;*<br>• *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;*<br>• *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5.* | -Тендерийн үр дүнг олон нийтэд мэдээлэх,<br>-Цахим хуудаснаас мэдээллийг тодорхой авах боломжтой байх,<br>-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байх,<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын хэрэгжилт бүрэн хангагдсан байх | Тухай бүр | ХАА-ны мэргэжилтнүүд | Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д давхардсан тоогоор 80 тендерийн үр дүнг бүрэн оруулж Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам болон холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тодорхой авах боломжийг бүрдүүлж ажиллалаа. Цахим тендерийн шалгаруулалт 100 хувьтай байна. |
| 13 | Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;*<br>• *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;*<br>• *Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай* | -Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах, гэрээ байгуулах урилгыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн байх,<br>-Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ төслийг цахим хуудсанд байршуулах,<br>-Гэрээнд авлига, ашиг сонирхлын | I, II улирал | ХАА-ны мэргэжилтнүүд | 2020 онд бараа ажил үйлчилгээ худалдан авах 48 тендерийн үнэлгээний хороонд ажилласан 25 гишүүнээр давхардсан тоогоор 254 ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг гаргуулан авч АТГ-ын “Цахим хуудас” , Шилэн дансны “Цахим хуудас”-д мэдээлж ажилласан.<br>“Монголын эрчим хүчний ассиоцаци” ТББ, “Үндэсний аж |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5.* | зөрчлөөс ангид байх заалт тусгах,<br>-Гэрээ байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулах,<br>-Мэдээллийн бааз үүсгэсэн байх | | | үйлдвэрийн зөвлөл", "Монголын эрчим хүчний мэргэшсэн инженерүүдийн зөвлөл", "Аудит боловсролын төв" ТББ, "Монголын эрчим хүч барилга угсралтын холбоо" ТББ, "Эрчим хотхон" ТББ зэрэг Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж, төлөөллийг үнэлгээний хороодын бүрэлдэхүүнд оруулан ажилласан байх боловч хамтран ажиллах гэрээ байгуулаагүй, хамтран ажиллах урилгыг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байдлыг хянан, заавар, зөвлөмж өгч хуулийн хүрээнд ажиллахыг анхаарууллаа. Улмаар "Байгууллагын Худалдан авах ажиллагааны журам" боловсруулан ажиллах санал гарч төслийн шатанд хянаж байна. |
| 14 | Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;*<br>• *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын* | -Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр),<br>-Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах ажилтны нэр, албан тушаал, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах,<br>-Улирлын мэдээ гаргаж, | Тухай бүр | ЗУХ | Иргэдээс байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, санал гомдол 2020 оны 12 сарын 22-ны байдлаар сарын байдлаар ирээгүй.<br>Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах ажилтны нэр, албан тушаал, харилцах утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | *зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;*<br>• *Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.* | шийдвэрлэлтийн байдлыг улирлаар мэдээлсэн байх,<br>-Цахим хуудсанд байршуулан мэдээлэх | | | |
| 15 | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр (тушаал, тогтоол)-ийг цахим хуудсанд байршуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5.* | -Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх,<br>-Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт), дүрэм, журам, заавярыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх | Тухай бүр | ЗУХ | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад тушаалын мэдээллийг сар бүр байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. |
| 16 | Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;*<br>*Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3.* | -ТББ-ын үйл ажиллагааг дэмжих,<br>-Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга (уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м)-д нэгдэх | Тухай бүр | ЭБАТ,<br>ЗУХ | Авлигатай тэмцэх талаар Удирдах дээд газар, ТӨБЗГ-уудаас ирсэн заавар, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн , Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас гаргасан уриалгыг хэвлэн самбарт байршуулж ажиллав. |
| 17 | Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах ***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;*<br>*-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1.* | -Ажилтнуудаас санал авах,<br>-Судалгааны үндсэн дээр эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлэх | IX сард | ЗУХ | Цаг үеийн байдал, ЭБАТ солигдсон зэргээс шалтгаалан зохион байгуулаагүй, 2021 онд зохион байгуулна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 18 | Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн тоог нэмэгдүүлэх, бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;*<br>• *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8.* | -Гэрчилгээ эзэмшигчийн нэрсийн жагсаалт, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах | Тухай бүр | ЗУХ | Гэрчилгээ эзэмшигч 14 ажилтны нэрсийн жагсаалт, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг тодорхойлон бүртгэлжүүлсэн.<br>Гэрчилгээний хугацаа дууссан 3 албан тушаалтныг 2020 онд сургалтанд хамруулж хугацааг сунгасан.<br>Гэрчилгээгүй ажилтныг үнэлгээний хороонд оруулж ажиллуулахгүй байх хяналтыг тавьж, заавар, зөвлөмжөөр хангаж ажиллаж байна. |
| **Хоёр. Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:** | | | | | |
| 19 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллүүдэд уулзалт, семинар зохион байгуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.* | -Уулзалт, семинар зохион байгуулах | XII сард | ХАА-ны мэргэжилтнүүд, ЭБАТ | “КОВИД-19” цар тахлын халдвараас сэргийлдэх бүх нийтийн бэлэн байдал зарлагдсан тул зохион байгуулаагүй. |
| 20 | Нийт албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомж, Эрх бүхий албан тушаалтнуудад мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.* | -Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтох,<br>-Сургалтад эрх бүхий албан тушаалтнууд, албан хаагчдыг хамруулсан байх | VIII-IX сард | ЭБАТ, Хуулийн мэргэжилтэн | “КОВИД-19”-тэй холбоотойгоор сургалтууд хойшилсон ч Эрх бүхий албан тушаалтнуудад шаардлагатай заавар зөвлөмжийг тухай бүр өгч , гарын авлага, хуулийн шаардлагатай материалаар хангаж ажилласан.<br>АТГ-ын ЭБАТ-уудад зориулж нээсэн цахим группэд 12 сарын 20-нд нэгдсэн.<br>Холбогдох мэдээ мэдээллийг авч сургалтад хамрагдана. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 21 | Ёс зүй, шударга ёс, харилцаа хандлага сэдвээр лекц уншуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.* | -Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан НАМЦ-аар ёс зүй, шударга ёс, харилцаа хандлагын чиглэлээр лекц зохион байгуулах,<br>-Нийт ажилтнуудыг хамруулсан байх | X, XI сард | Сургалтын мэргэжилтэн, Соёл олон нийтийн ажил хариуцсан мэргэжилтэн | Байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-тэй хамтарч нийт ажилчдыг нэгтгэсэн Ёс зүйн зөвлөл цахим хуудсыг нээж, холбогдох мэдээ мэдээлэл өгч байна. |
| 22 | Шинэ ажилтны сургалт болон сар, жилийн давтан зааварчилгааны сургалтын хуваарьт Авлигын эсрэг соён гэгээрүүлэх асуудлаар тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.* | -Сургалтыг ЭХЯ болон АТГ-тай хамтран зохион байгуулах, сургагч багш авах,<br>-Сургалтад нийт ажилтнууд хамрагдсан байх | Жилийн турш | ЭБАТ, Сургалтын мэргэжилтэн | АТГ-тай хамтарч 11,12 сард сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн боловч “КОВИД-19” цар тахлын халдвараас сэргийлэх бүх нийтийн бэлэн байдал зарлагдсан тул зохион байгуулаагүй. |
| **Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон түүний төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр:** | | | | | |
| 23 | Ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.1.2-1, 6* | -Ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх,<br>-Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг хангах | X сард | Хүний нөөцийн мэргэжилтэн | Компанийн эрх бүхий албан тушаалтны эрхлэх асуудал, ажлын байрны үндсэн чиг үүрэгт тавигдах мэргэжил ур чадварын болон бусад шаардлагыг нэгдсэн нэг стандартад оруулан, мөрдөн ажиллаж байна. |
| 24 | Байгууллагын ажилтны ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцэх арга хэмжээ авах, салбарын болон байгууллагын ёс зүйн дүрмийг мөрдөх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.1.6.3* | -Байгууллагын Ёс зүйн хорооны шийдвэрийн санг бүрдүүлсэн, тайлагнасан байх,<br>-Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх,<br>-Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн хороо, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх | Жилийн турш | Хуулийн мэргэжилтэн, Ёс зүйн хороо | “Эрчим хүчний салбарын төрийн өмчит байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу ЭХЯ-нд тус байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-өөс хийсэн ажлын тайланг 2020.07.10-ны өдрийн 01/342 дугаар албан тоотоор хүргүүлсэн байна.<br>Тус зөвлөл нь байгууллагын ажилтны “Ёс зүйн дүрэм”-ийг ГЗ-ын 2020.03.13-ны өдрийн А/54 дугаар тушаалаар шинэчлэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | батлуулсан. Дүрмийг хананд ил тод харагдахуйц байдлаар байршуулж, нугалбар хэлбэрээр 400 ширхэгийг хэвлүүлэн ажилтнуудад тараан сурталчилсан байна. Шинэ орж буй ажилтанд тухай бүр танилцуулан ажиллаж байна. Санал авах хайрцаг шинээр хийж байршуулсан ба төлөвлөгөөт оны байдлаар тус зөвлөлд ямар нэг гомдол санал ирээгүй байна. |
| 25 | Аудитын байгууллагын акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.3.7.1* | -Аудитын дүгнэлтийн хэрэгжилт сайжирч, зөрчлийг арилгасан байх | II-р улирал | СБХ | “Нийслэлийн аудит” ХХК-ийн 2020.03.13-ны өдрийн аудитын тайлан, зөвлөмжийн дагуу үндсэн Хөрөнгийн элэгдлийн тооцооллыг холбогдох хууль, стандартад нийцүүлэн тооцож, данс бүртгэлд тусган ажиллаж байна. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг “Мөнх оргил трейд” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн. |
| **Дөрөв. Авлигын эрсдэлийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийг хэрэгжүүлэх чиглэлээр:** | | | | | |
| 26 | Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.1, 5.1* | -Авлигын эрсдэлийг зөв тодорхойлсон байх /Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын туслалцаа авах/ | III-р улирал | ЭБАТ | -АТГ-ын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн 3 албан тушаалтныг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилсон.<br>- Авлигын эрсдэлийг тодорхойлох сургалтыг цахимаар судалсан. Тодорхойлох ажлыг Бүх нийтийн бэлэн байдалтай холбоотойгоор зохион байгуулаагүй, гэвч цахимаар зохион байгуулахаар бэлтгэл хангаж байна. |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 27 | Авлигын эрсдэлийн үнэлгээний хэрэгжилтийг хангах<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>• *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.1.1.5.1* | -Авлигын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байх. | III,IV-р улирал | ЭБАТ, Холбогдох ажилтнууд | АТГ, ЭХЯ-аас өгсөн удирдамж, зөвлөмж, Авлигын эсрэг хууль. *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, холбогдох арга хэмжээнүүдийг зохион байгуулж эрсдэлээс сэргийлэн ажиллаж байна.* |
| **Тав. Бусад цаг үеийн шинжтэй зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | |
| 28 | Эрчим хүчний яам, Авлигатай тэмцэх газар болон бусад дээд газраас ирүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх<br>**Эрх зүйн үндэслэл:**<br>• *Эрчим хүчний сайдын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн а/512 дугаар "Зөвлөмж хүргүүлэх тухай" албан бичиг* | -Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байх | Жилийн турш | ЭБАТ, Холбогдох ажилтнууд | - Эрчим хүчний сайдын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн а/512 дугаар "Зөвлөмж"-ийг Худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүдэд танилцуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.<br>- ЭХЯ - Төрийн нарийн бичгийн даргын 2020.12.11-ний в/4119 дугаар албн тоотын хэрэгжилтийг тус тус хангаан ажиллаж байна. |

ГҮЙЦЭТГЭЛ ГАРГАСАН:

"ДЦС-2" ТӨХК-ИЙН
ЭБАТ Д.АЛТАНТУЯА.